



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/35

Бор-Өндөр

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан  
сэргийлж, гамшгийн аюулын зарлан мэдээллийн  
дохиогоор ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дүгээр зүйлийн 66.1, 66.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр Тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2024 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн 16:00 цагт сумын хэмжээнд зохион байгуулсугай.
2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг өндөр түвшинд зохион байгуулахыг нийт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд үүрэг болгосугай.
3. Хийгдэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
4. Арга хэмжээнд шаардагдах 1.710.000 (нэг сая долоон зуун арван мянган) төгрөгийг гамшгийн эрсдлийн сангийн хөрөнгөөс гаргахыг Санхүү албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.
5. Мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Бор-Өндөр сум дахь Онцгой байдлын хэлтсийн дарга (хошууч Г.Мөнхнаран)-д даалгасугай.
6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ